7.4 Суралцагчийн бүлэг солих

7.4 Суралцагчийн бүлэг солих үйлдэл

Энэхүү үйлдлийг суралцагчийг сургууль дотроо бүлэг солих бүртгэлийг хийхэд ашиглана. Суралцагчийн бүлэг солих үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **Суралцагч** үйл ажиллагааг сонгоно.

2. Үйлдэл хэсгээс **Бүлэг солих** товчийг дарна.

Бүлэг солих үйлдлийг дараах байдлаар гүйцэтгэнэ.



Бүлэг солих үйлдэл сонгосны дараа "Бүлэг солих үйлдэл" цонх гарна. Энэхүү цонхноос тухайн бүлэг солих суралцагчийг сонгоно.

1. Сургалтын хөтөлбөр сонгоно. Ж: Бүрэн дунд боловсролын өдрийн хөтөлбөр

2. Анги сонгоно. Ж: 10-р анги

3. Бүлэг сонгоно. Ж: 10-а

4. Жагсаалтаас суралцагчийн нэрийн өмнөх дөрвөлжинг чагтална.

5. **Суралцагч сонгох** үйлдлийг гүйцэтгэнэ.



Суралцагч сонгох үйлдлийн дараа бүлэг солих мэдээллийг бүртгэнэ.

1. Шилжүүлж буй бүлгийг сонгоно. Ж: 10-б

2. Үйлдэл хийсэн улирал сонгоно. Ж: 2018-2019 хичээлийн жил, 1-р улирал

3. Үйлдлийн шалтгаан сонгоно. Ж: Сургалтын байгууллагын шийдвэрээр

4. Шилжилт хөдөлгөөн хийсэн огноог сонгоно. Ж: 2018-08-31

5. **Хадгалах** товч дарснаар бүлэг солих үйлдэл баталгаажна.



Анхаарах нь:

Цуцлагдсан, Батлагдаагүй, Хянагдаж байгаа төлөвт байгаа суралцагчид бүлэг солих хөдөлгөөн хийх боломжгүй. Зөвхөн **батлагдсан** төлөвтэй сурагчид хөдөлгөөн хийгдэнэ. Бүлэг солих үйлдэл хийсэн үед заавал баталгаажуулах хүсэлт илгээх шаардлагагүй.